



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ХҮДЭР СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
МОНГОЛ АРДЫН НАМД

2024.08.07 № ГНАГ-2024/13-МТА-НА-16

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын

018020591

нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Монгол Ардын намын Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт арга, хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хүдэр сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр (...<sup>8</sup> хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хүдэр сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮДЭР СУМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2024.06.01

**БИДНИЙ УРИА:** ХАМТЫН ХҮЧЭЭР СУМАА ХӨГЖҮҮЛБЕ.  
ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХҮЧЭЭ НЭГТГЭЕ.



Хүдэр нутгийнхаа зон олны итгэл, сонголтыг хүлээн ялалт байгуулахыг зорьж Монгол Ардын Нам ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудтайгаа хамтран хичээл зүтгэлтэй ажиллаж ирсэн билээ.

Бид бүхэн орон нутгийнхаа иргэдийн ололт амжилт, хуримтлуулсан туршлага, нөөц боломжид тулгуурлан ирэх 4-н жилд “Хамтын хүчээр сумаа хөгжүүлбэ, Хөгжлийн төлөө хүчээ нэгтгэе” уриатайгаар та бидний өмнө тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэхээр энэхүү хөтөлбөрөө боловсруулж Хүдэр сумын нийт ард иргэд, сонгогч танаа танилцуулж байна.

**Нэг. Нийгмийн бодлого**

**1.1. Эрүүл мэнд**

*Эрүүл мэндийн хувьд хүн амд ээлтэй, тэгш хүртээмжтэй, чанартай эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэнэ.*

- 1.1.1 Урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгийг үргэлжлүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн хоёр жилд тутамд бүрэн хамруулахад эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллана.
- 1.1.2 Жил бүр ахмадуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 1-ээс доошгүй удаа хамруулах арга хэмжээ авна.
- 1.1.3 Хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, улирал тутамд явуулын баг ажиллуулж, малчин өрх бүрд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлнэ.
- 1.1.4 Суманд шүдний кабинет, шүдний эмчтэй болох асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.
- 1.1.5 Сумын Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж эмэгтэйчүүдийн эхо аппараттай болно.
- 1.1.6 Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн ажилтнуудыг мэргэшүүлж, мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн ханган, иргэдэд үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

1.1.7 Эмч, эмнэлгийн ажилтнуудын ажиллах нөхцөлийг бүрдүүлж, хэвтэн эмчлүүлэгчдийн тав тухтай нөхцөлийг хангана.


## **1.2. Боловсрол, соёл, спорт**


*Эрдэм боловсролтой, түүх ёс заншил, уламжлалт соёлоо дээдэлсэн “Зөв монгол хүүхэд”-ийг төлөвшүүлнэ.*

- 1.2.1 ЕБС-ийн байгалийн ухааны лабораторийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнийг нэмж хичээл, сургалт хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.2.2 Орон нутаг судлах танхимыг нутгийн онцлогт тохируулан түүх, соёл, өв уламжлалаа сэргээн, Соёлын өргөөтэй болно.
- 1.2.3 Багийн иргэд, аж ахуйн нэгж байгууллагын дунд жил бүр урлаг спортын тэмцээн зохион байгуулна.
- 1.2.4 ЕБС-ийг мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангаж, ажлын байранд мэргэжил, ур чадвараа дээшлүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.2.5 Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулж, ая тухтай сурч, хүмүүжих орчин нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.2.6 Бага дунд боловсролын чанарыг дээшлүүлэхэд боловсролын байгууллагын үйл ажиллагааг чиглүүлж, хүүхдийн өөрийнх нь авьяаст тулгуурлан хөгжүүлж, амьдралын зөв дадалд сургана.
- 1.2.7 СӨБ-ын орчинг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй таатай орчинд хүмүүжих нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.2.8 Соёлын төвийг мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангах, шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг соёлын байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- 1.2.9 Хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 3\*3 сагсан бөмбөгийн стандарт талбайг 2 багт шинээр байгуулна.
- 1.2.10 Олон улсын болон тив дэлхий, улс аймгийн урлаг спортын тэмцээнд оролцох иргэдийг бүх талаар дэмжинэ.
- 1.2.11 Иргэдийг идэвхитэй хөдөлгөөн хийх үйл ажиллагааг дэмжиж, нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.

## **1.3. Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, жижиг дунд үйлдвэрлэл.**

*Нийгмийн халамжийн боломжит бүх үйлчилгээг шуурхай хүргэж, баялаг бүтээгчдийг дэмжиж, өрх бүрийн орлогыг нэмэгдүүлэн ядуурлыг бууруулна.*



- 
- 1.3.1 Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх талаар баримтлах сумын бодлого боловсруулж, хэрэгжүүлж ажиллана.
- 1.3.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалтуудыг зохион байгуулахад санал санаачилга гарган төсөл хөтөлбөрт хамруулж, хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлнэ.
- 1.3.3 Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ТББ-уудтай идэвхтэй хамтран ажиллана.
- 1.3.4 Уул уурхайн нарийн мэргэжлийн курст суралцаж, мэргэжил эзэмшсэн залуучуудыг байнгын ажлын байраар хангах асуудлаар уул уурхайн үйлдвэрлэл эрхэлж буй хувийн хэвшлийн байгууллагатай хамтарч ажиллана.
- 1.3.5 Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг жил бүр хөнгөлөлттэй амралт сувилалд амруулна.
- 1.3.6 Ганц бие ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрхийг түлээ, түлшээр хангах талаар аж ахуй нэгжүүдэд уламжлан анхаарч ажиллана.
- 1.3.7 Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж " Монгол гэрийн мод, гэр ахуйн модон эдлэл" үйлдвэрлэлийг үргэлжлүүлэн дэмжиж, сумын брэнд бүтээгдэхүүнтэй болох талаар санал санаачилгыг дэмжин ажиллана.
- 1.3.8 Хус, нарсан ойн нөөцийг ашиглан хавтан, модон эдлэлийн үйлдвэрлэл явуулах иргэд, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
- 1.3.9 Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.3.10 Өрхийн үйлдвэрлэлийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжиж, бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээ бий болгон, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан авах бодлогыг хэрэгжүүлнэ.

### **Хоёр. Эдийн засгийн бодлого.**

#### **2.1. Хүнс, хөдөө аж ахуй**

*Байгаль цаг уурын эрсдэл даах чадвар бүхий эрчимжсэн мал аж ахуй газар тариалангийн салбарыг хөгжүүлнэ.*


- 2.1.1 Хагас эрчимжүүлсэн мал аж ахуй эрхлэгчдийг дэмжин, үйлдвэр угсааг сайжруулж, сүү мах, ноос ноолуур, таваарлаг чанарыг нэмэгдүүлэн сайн үүлдрийн хээлтэгч, хээлтүүлэгчээр хангахад бодлогоор дэмжиж ажиллана.

- 2.1.2 Сум орон нутагт сүү хөргөх төхөөрөмж бүхий хөргүүрийг шинээр суурилуулахад хувийн хэвшлийн байгууллагатай хамтарч ажиллана.
- 2.1.3 Мал эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулж явуулын үзлэг, оношилгоо эмийн үйлчилгээг тогтмолжуулахад анхаарч ажиллана.
- 2.1.4 Хүн, мал амьтны усан хангамжийг сайжруулж, бэлчээрт худаг уст цэгийн тоог нэмэгдүүлж зүй зохистойгоор бэлчээрийн даацыг ашиглах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.1.5 Өрхийн үйлдвэрлэгч, хоршоо, бүлгийн үйл ажиллагааг бодлогоор дэмжиж төмс, хүнсний ногоо, зоорь, хүлэмж, зөгийн аж ахуйг нэмэгдүүлнэ.
- 2.1.6 ХАА-н бүтээгдэхүүнийг жилийн дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- 2.1.8 Тариалангийн үйлдвэрлэлд таримлын зохистой сэлгээ мөрдөж, сэлгээнд ашигт таримал тариалсан, шинээр усалгаатай тариалан эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжин санал санаачилгыг дэмжин ажиллана.
- 2.1.9 Бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх зорилгоор алсын бэлчээрийг усжуулах, зам, давааг засан сайжруулах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлнэ.
- 2.1.10 Мал эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- 2.1.11 Төмс, хүнсний ногоо тариалж байгаа ногоочдыг дэмжиж, хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.
- 2.1.12 Хөдөөгийн малчдад зориулж үүрэн телефоны антеныг нэмэгдүүлэх асуудлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- 2.1.13 Зорилтот бүлгийн өрхүүдийн амьжиргааг дэмжих зорилгоор малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.1.14 Өвөлжилт хүндэрсэн үед малчдыг малын тэжээлээр хангахад дэмжлэг үзүүлж ажиллана.

## **2.2. Байгаль орчин**

*Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулж нөхөн сэргээх, усны эх үүсвэрийн хамгаалалтыг сайжруулна.*


- 2.2.1 Сумын байгаль орчны талаар баримтлах цогц бодлогыг шинэчлэн боловсруулж, хууль тогтоомжийн дагуу мөрдүүлж ажиллана. /Сумын ойн нөөцийг тогтоож, ойн менежментийн төлөвлөгөөг шинэчлэх гэх мэт /

- 
- 2.2.2 Шинээр баригдах барилга байгууламжийн эргэн тойронд ногоон байгууламж байгуулах асуудлыг зохион байгуулж, орчны хог, хаягдлын сөрөг нөлөөллийг багасгана.
- 2.2.3 Сумын төвийн хогийн цэгийг хашаажуулж, хогийн цэгийг иргэдийн саналд тулгуурлан шийдвэрлэнэ.
- 2.2.4 Бүх нийтээр мод тарих үндэсний хөтөлбөр буюу "Тэрбум мод" хөтөлбөрийн хүрээнд айл өрх, албан байгууллага бүрт жимс, жимсгэнийн болон гоёлын мод бут тарих санаачилгыг дэмжиж, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэхэд иргэдийн оролцоог идэвхжүүлнэ.
- 2.2.5 Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах, ойн зурвас байгуулах ажлыг шат дараатай зохион байгуулна.
- 2.2.6 Булаг шандын эхийг хамгаалж, хашаажуулж, хамгаалалтыг сайжруулна. /Жаргалант, Номтын рашаан, Баянцагааны булаг... /
- 2.2.7 Байгаль орчноо хамгаалж, ажилгүй иргэдээр ойн цэвэрлэгээ хийлгүүлж зэргэлдээх сумдын түлшний хэрэгцээг хангана.
- 2.2.8 Уул уурхайн олборлолт явагдаж орхигдсон газруудыг байгальд хоргүй аргаар дахин ашиглуулан нөхөн сэргээх бодлогыг бичил уурхай эрхлэгчид, нөхөрлөлүүдээр хийж гүйцэтгүүлэхэд бодлогоор дэмжин ажиллана.
- 2.2.9 Гол усны урсац бүрдэх эх, ойн сан болон усны сан бүхий газарт ашигт малтмал эрж хайх, олборлохыг хориглох тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, уул уурхайн нөхөн сэргээлтийг хийлгэх ажлыг зөвшөөрөлтэй эрх бүхий аж ахуй нэгжүүдээр гүйцэтгүүлнэ.
- 2.2.10 Сумын аялал жуулчлалын маршрут баталж, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал, жуулчлалыг хөгжүүлэн, 4 улирлын аяллыг хөгжүүлнэ.

### **2.3. Дэд бүтэц, хөрөнгө оруулалт, худалдаа үйлчилгээ**

*Орон нутгийн хөгжлийг эрчимжүүлж, иргэд оршин суугаа газартаа ая тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ.*

- 2.3.1 Соёлын төвийн барилгыг шинээр барих ажлыг эрчимжүүлж, тоног төхөөрөмж хэрэгслүүд дээр анхаарч ажиллана.
- 2.3.2 Цахилгаан эрчим хүч дамжуулах сумын төвийн хорооллын дундах 0.4 кв-ын шугамыг засварлаж, эрчим хүчний доголдлыг арилгаж, хүчдэлийг тэнцвэржүүлнэ.

- 
- 2.3.3 Хоггүй сум болох аяныг өрнүүлж, хог хаягдлыг дахин боловсруулах цехийг бий болгох, нийтийн эзэмшлийн гудамж талбайд хогийн савыг нэмэгдүүлж, хог хаягдлыг багасгах санал санаачилгыг дэмжиж ажиллана.
- 2.3.4 Сумын төвийн айл өрхүүдийн дунд уст цэг, цахим худгийн тоог нэмэгдүүлж, засвар үйлчилгээ хийж, ашиглалтыг сайжруулна.
- 2.3.5 Иргэдийнхээ аятай тухтай амьдрах нөхцөлийг хангаж, худалдаа үйлчилгээний чанар стандартыг сайжруулах нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллана.
- 2.3.6 “Хүдэрт үйлдвэрлэв” сумын брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг бүрэн хангаж ажиллуулах талаар санал санаачилгыг дэмжин ажиллана.
- 2.3.7 Сумын төвийн хорооллуудад гудамжны гэрэлтүүлэг шинээр суурилуулж, гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.
- 2.3.8 Цахилгаан үйлдвэрлэх сэргээгдэх эрчим хүчний нарны станцыг мэргэжлийн байгууллагатай хамтран байгуулж, цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.
- 2.3.9 Сумын төвд “Био” нийтийн бие засах газрыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр байгуулна.
- 23.10 Хүдэр голын эрэг дагуу чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх талбай шинээр байгуулах, тохижуулах асуудлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэнэ.
- 23.11 Сумын төвийн камержуулалтын тоог нэмэгдүүлэх асуудлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлэж, ард иргэдийн аюулгүй байдлыг хангана.

#### **2.4. Төсөв санхүү**

*Төсвийн ил тод байдлыг иргэдэд нээлттэй болгож, шилэн дансны хяналтыг чанаржуулна.*

- 2.4.1 Орон нутгийн орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөж, төсвийн бүрдүүлэлт, зарцуулалт, гүйцэтгэлийг иргэдэд ил тод мэдээлж ажиллана.
- 2.4.2 Төсвийн хөрөнгө оруулалт, худалдан авалт, тендер сонгон шалгаруулалт болон гүйцэтгэлд иргэдийн оролцоотойгоор хяналт тавьж, шударгаар дүгнэж, иргэдэд мэдээлж тайлагнана.
- 2.4.3 Орон нутгийн төсөв болон Хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгийг иргэдийн оролцоотой төлөвлөн, тэдний амин чухал хэрэгцээг хангахад зориулан мэдээллийг багийн иргэдийн нийтийн хуралд ил тод мэдээлнэ.



## Гурав. Нутгийн захиргаа хууль эрх зүйн бодлого

### 3.1. Төрийн захиргаа

*Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулна.*

- 3.1.1 Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, иргэдийн чирэгдэл, зардлыг багасгах зорилгоор төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, хүргэх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллана.
- 3.1.2 Багш, эмч, сувилагч, соёлын ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг сайжруулах, туршлага эзэмшүүлэх зорилгоор дотоодод туршлага судлуулах, сургалтад хамруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана.
- 3.1.3 Төрийн нууцад хамаарахаас бусад сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас гарч буй төрийн тогтоол, шийдвэр, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг олон нийтэд ил тод нээлттэй болгоно.
- 3.1.4 Төрийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлж, мэдээллийг ил тод, шилэн байлгана.
- 3.1.5 Төрийн албан хаагчийн ёс зүй, хандлагыг ажлын гүйцэтгэлийн үнэлгээний чухал хэсэг болгон хэвшүүлж, үйлчилгээний соёлыг дээшлүүлнэ.
- 3.1.6 Төрийн албан хаагчийн тасралтгүй сурч хөгжих тогтолцоог бүрдүүлж, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, нийгмийн баталгааны зохистой бодлогыг баримтална.
- 3.1.7 Бүх нийтээр дагаж мөрдүүлэх хэм хэмжээний шийдвэрийг гаргахаас өмнө иргэд, иргэний нийгмийн байгууллагаар үнэлүүлдэг тогтолцоог бүрдүүлнэ.
- 3.1.8 Төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг дэмжинэ.
- 3.1.9 Төрийн аливаа шийдвэр гаргалтад хүний эрхийн мэдрэмжтэй хандаж, хүний эрхийг зөрчсөн шийдвэрийг цуцалж, төрийн хүнд суртлыг арилгана.

### 3.2. Хууль хяналт

*Иргэдийн аюулгүй байдлыг хангаж хууль ёсыг сахиулна.*

- 3.2.1 Байгаль орчныг хамгаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдэд эрх зүйн боловсрол эзэмшүүлэх сургалт, сурталчилгааны ажил хийх болон иргэд албан байгууллагын дунд сурталчлах ажлыг байгаль орчин, цагдаагийн хэсэгтэй хамтран хэрэгжүүлнэ.

3.2.2 Эрэн хайх аврах салбарын үйл ажиллагааг дэмжин тоног төхөөрөмж болон авто граж барьж байгуулах ажлыг дэмжин ажиллана.

3.2.3 Малын хулгайтай тэмцэх зорилгоор малчдын зөвлөлийн хурлыг тогтмолжуулж, "Сайн хөршийн холбоо"-г бий болгон, дэмжиж ажиллана.



**ХҮДЭР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**